



# ЭДИЙН ЗАСАГ: онол, практик

№209 (09)

2003

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ҮНДСЭН СУБЪЕКТҮҮДИЙН  
ХООРОНДЫН САНХҮҮГИЙН ХЭЛХЭЭ ХОЛБОО



## АГУУЛГА

### Сэтгүүлийн редакцийн ЗӨВЛӨЛ

Дарга: **Б. Сувд**

Гишүүд:

**Д. Дагвадорж**

**П. Лувсандорж**

**Г. Миезгомбо**

**Э. Сайнбилэг**

**Б. Сайнжаргал**

Н/Б дарга **Х.Энхмөнх**

#### ХАЯГ:

Улаанбаатар 46-А/121  
Монгол Улсын Их  
Сургууль  
Эдийн засгийн Сургууль

УТАС: 350997

ФАКС: 976-11-350994

И-МЭЙЛ:

webmaster@ses.edu.mn

© 2003. МУИС-ийн Эдийн  
засгийн сургууль  
Эдийн засгийн  
боловсрол холбоо

Өмнөх үг .....	3
Зохиогчид .....	4
1. <b>Д.Дуламсүрэн, А.Энхбат</b> Макро эдийн засгийн санхүүгийн хөтөлбөр боловсруулах асуудал .....	5
2. <b>Д.Намжил, Н.Батжаргал</b> Төрийн санхүүгийн удирдлагын шинэчлэл .....	13
3. <b>Ц.Аюурзана, Н.Баяртсайхан</b> Санхүүгийн өөрчлөн байгуулалтын арга зүйн асуудалд .....	18
4. <b>А.Цэрэнтогоо</b> Банкнаас гадуурх мөнгөний өнөөгийн байдал .....	29
5. <b>Д.Цэрэнпил</b> Инфляцийн шинжилгээ, дүгнэлт, санал .....	35
6. <b>Л.Оюун</b> Банкны маркетинг ба реклам ...	48
7. <b>С.Баатар, С.Анхбаяр</b> Эдийн засгийг татварын бодлогоор зохицуулах нь .....	53
8. <b>С.Баатар, Ч.Энхбаяр</b> Татварын онолын үзэл баримтлалын зарим асуудалд .....	59
9. <b>Г.Бурмаа</b> Монгол улсын даатгалын зах зээлийн өнөөгийн байдал .....	65
10. <b>Ж.Уянга</b> Даяарчлалын асуудал .....	70
11. <b>Р.Гансүх</b> Гадаадын хөрөнгө оруулалтын татварын орчин .....	75
12. <b>К.Аксолтан</b> Эдийн засгийн суурь салбарын нөөцийн хөгжил .....	79
13. <b>П.Лувсандорж</b> Үндэсний эдийн засгийн хөгжлийн суурь асуудлууд .....	85
<b>Хавсралт:</b> МУИС-ийн ЭЗС-ийн Санхүүгийн тэнхмийн танилцуулга, сургалтын хөтөлбөр .....	91

# Editorial Board

Editor in chief: **B. Suvd**

Board members:

**D. Dagvadorj**

**P. Luvsandorj**

**G. Miyegombo**

**E. Sainbileg**

**B. Sainjargal**

Secretary:

**Kh. Enkhmunkh**

### ADDRESS:

Ulaanbaatar 46-A/121  
National University of  
Mongolia  
School of Economic Studies

**TELEPHONE: 350997**

**FAX: 976-11-350994**

**E-MAIL:  
webmaster@ses.edu.mn**

## CONTENTS

Preface .....	3
Authors .....	4
1. <b>D.Dulamsuren, A.Enkhat</b> Developing a macroeconomics financing programme ....	5
2. <b>D.Namjil, N.Batjargal</b> Reform of state finance management .....	13
3. <b>Ts.Ayurzana, N.Bayartsaikhan</b> Method ological issues of financial reform ..	18
4. <b>A.Tserentogoo</b> Present status of money outside banks .....	29
5. <b>D.Tserenpil</b> Analysis of inflation, conclu- sions, suggestions .....	35
6. <b>L.Oyun</b> Marketing & advertising of banks ..	48
7. <b>S.Baatar, S.Ankhbayar</b> Coordinating economy with taxation loplcy .....	53
8. <b>S.Baatar, Ch.Enkhbayar</b> Some issues of theoretical concepts of taxation .....	59
9. <b>G.Burmaa</b> Present condition of Mongolian insurance market .....	65
10. <b>J.Uyanga</b> Globalization problems .....	70
11. <b>R.Gansukh</b> Tax environment for foreign investment .....	75
12. <b>K.Aksoltan</b> Resource development of the basic economic branch .....	79
13. <b>P.Luvsandorj</b> Fundamental problems of national economic development .....	85
<b>Appendix: Introduction of the Financial Depart- ment of the School of Economic Studies, National University of Mongolia, curriculum .</b>	<b>91</b>

## ӨМНӨХ ҮГ

“ЭДИЙН ЗАСАГ: онол, практик” сэтгүүлийн энэхүү дугаарыг МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн Санхүүгийн тэнхмээс эрхлэн гаргав.

Шилжилтийн эдийн засагт нэн чухал ач холбогдолтой санхүү, банкны шинэ тогтолцоог төлөвшүүлэх, бэхжүүлэх, хөгжүүлэх; үндэсний эдийн засгийн хөгжилд санхүүгийн секторын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд чиглэсэн шинжлэх ухаан, амьдралын олон чухал асуудлыг хөндсөн шинэ мэдлэгтэй багш, судлаачдын сонирхолтой өгүүлэлүүдтэй энэ дугаараас танилцах болно.

Сэтгүүлийн энэ дугаарт санхүүгийн секторыг бэхжүүлэх, хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулах, төрийн санхүүгийн удирдлагыг шинэчлэх, санхүүгийн шинэчлэлийн арга зүйг боловсронгуй болгох, санхүү, мөнгөний бодлогын үйлчлэлийн хүрээг тэлэх, банкны тогтолцооны хүч чадлыг нэмэгдүүлэх талаар явуулсан эрдэмтэд, судлаачдын судалгааны шилдэг гэж болох үр дүнгээс оруулан нийтэлж байна.

Эцэст нь, багш, судлаачдын идэвх зүтгэл, үр бүтээлтэй үйл ажиллагааны үр дүнд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн Санхүүгийн тэнхим нь орчин үеийн шинжлэх ухааны сургалт, судалгааны шинэ төв болон өсч байгааг бахдалтай тэмдэглэж байна.

Манай сургууль санхүүгийн мэргэшлүүдээр сургалтын агуулгыг шинэчлэж, өргөтгөсөн хөтөлбөрөөр макро, микро эдийн засгийн санхүү; санхүү, мөнгөний бодлого; санхүү, банкны менежмент; банкны маркетинг, хяналт, шинжилгээ; татвар, даатгал; олон улсын валют, санхүүгийн чиглэлүүдээр сургалт, судалгаа явуулдаг. Манай сургуульд санхүүгийн мэргэшлүүдээр суралцаж байгаа бакалавр, магистр, докторын тоо жилээс жилд өсч байгаа, бидний судалгаа хийдэг төсөл, сэдвийн тоо ч нэмэгдэж байгаа, Та бүхэнтэй хамтран ажиллах хүсэл, сонирхол бидэнд бас байгаа.

**Б.Сувд  
П.Луvsандорж**

ЗОХИОГЧИД

1. **Д.Дуламсүрэн.** МУИС-ийн ЭЗС-ийн Санхүүгийн тэнхмийн эрхлэгч, доктор Ph, тэргүүлэх профессор. "Олон улсын эдийн засаг, санхүүгийн зэх зээл, валютын асуудал"-ыг судалдаг. Сүүлийн жилүүдэд хэвлэгдсэн гол бүтээлүүд: "Олон улсын валютын харилцаа", "Үнэт цаас үнэт цаасны зах зээл" номуудыг бичиж хэвлүүлсэн. 2 ном редакторласан. 2002 онд эрдэм шинжилгээний өгүүлэл 4-ийг нийтлүүлсэн. Эрдэм шинжилгээний 2 илтгэл тавьж хэлэлцүүлсэн. 2003 онд 2 номын эх бэлтгэж байна. "Монгол улсын макро эдийн засгийн санхүүгийн хөтөлбөр" сэдэвт ажлыг удирдан гүйцэтгэж дуусах шатандаа орж байна. МУИС-аас гадуур 2 төслийн ажилд оролцдог.
2. **А.Энхбат.** Засгийн газрын хэрэг эрхлэх газрын санхүү эдийн засгийн асуудал хариуцсан референт. МУИС-ийн докторант. болон их сургуулийн сэтгүүлд хэвлүүлсэн. "Хөгжлийн эдийн засгийн асуудал" сэдвээр судалгааны ажил хийдэг. Сүүлийн жилүүдэд эрдэм шинжилгээний 3 өгүүлэл академи болон их сургуулийн сэтгүүлд хэвлүүлсэн.
3. **Д.Намжил.** МУИС-ийн ЭЗС-ийн Санхүүгийн тэнхмийн профессор багш, доктор Ph. "Төрийн санхүү-мөнгөний бодлого" сэдвээр судалгаа хийдэг. Санхүү, мөнгөний бодлого судалгааны чиглэлээр их дээд сургуулийн оюутан, магистрт зориулсан 5 сурах бичиг 90 гаруй эрдэм шинжилгээ судалгааны өгүүлэл, нийтлүүлэг хэвлүүлсэн.
4. **Н.Батжаргал.** МУИС-ийн ЭЗС-ийн Санхүүгийн тэнхмийн дагалдан багш, эдийн засаг бизнесийн удирдлагын магистр. "Төсөв, татвар"-ын чиглэлээр судалгаа хийж байгаа. "Татварын онол, тогтолцоо" номын нэг бүлгийг бичихэд оролцсон бөгөөд одоо удахгүй хэвлэгдэнэ. ТБУСТХуулийн төслийг хэрэгжүүлэх багийн гишүүнээр ажиллаж байгаа.
5. **Ц.Аюураана.** МУИС-ийн ЭЗС-ийн Санхүүгийн тэнхмийн профессор багш, эдийн засгийн шинжлэх ухааны доктор, тэргүүлэх профессор. "Санхүү, менежмент"-ийн чиглэлээр судалгааны ажил хийдэг. Сүүлийн жилд хэвлэгдсэн гол бүтээлүүд: "Өөрийгөө санхүүжүүлэх зарчим", УБ., УХГ. 1991; "Бүртгэл, санхүү, банкны тогтолцооны шинэ загвар" (Эрдэм шинжилгээний төслийн тайлан), УБ., 2001; "Аж ахуйн нэгжийн санхүү" УБ, 2001; "Монгол улсын эдийн засгийн хөгжлийн онол, практикийн асуудалд" өгүүлэл. "Бүртгэл, санхүү, аудит" сэтгүүл. 2002, №2
6. **Н.Баяртсайхан.** УИХ-ын гишүүн, төсвийн байнгын хорооны дарга. Судалгааны чиглэл: "Хөдөө аж ахуйн эдийн засаг, зохион байгуулалт, санхүү-төсвийн харилцаа, төрийн зохицуулалт". Гол бүтээлүүд: "Монголын нийгмийн өөрчлөн байгуулалт" УБ., 2000; "Төрийн зохицуулалтын асуудал" 2003; "Эдийн засгийн аюулгүй байдал" УБ., 2002 (нэг бүлэг); "Глобалчлал ба Монгол улс" өгүүлэл (Олон сонин сэтгүүлд хэвлэгдсэн) 2002;
7. **А.Цэрэнтогтоо.** МУИС-ийн ЭЗС-ийн Санхүүгийн тэнхмийн ахлах багш, магистр. "Банкны үйл ажиллагааны шинжилгээ" сэдвээр судалгаа хийдэг. Энэ сэдвээр ном бичсэн. Банкны хүүгийн эрсдэлээс хамгаалах арга, өөрийн хөрөнгийн удирдлага, татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлага сэдвүүдээр гарын авлага гаргасан. "Банкны менежмент" сурах бичиг бичиж байгаа.
8. **Д.Цэрэнпил.** МУИС-ийн ЭЗС-ийн Санхүүгийн тэнхмийн зөвлөх профессор. Эдийн засгийн шинжлэх ухааны доктор, профессор. "Санхүү", "Мөнгө зээл", "Хөгжлийн эдийн засаг", "Хөгжлийн эдийн засаг" чиглэлээр судалгааны ажил хийдэг. Сүүлийн жилд хэвлэгдсэн бүтээлүүд: "Санхүүгийн бодлого" УБ., 1999; "Диссертаци бичих, хамгаалах арга зүйн зөвлөмж" УБ., 2001; "Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдлын зарим асуудал" УБ., 2002; "Банкны зээлийн шинжилгээ" УБ., 2003, (хамтын бүтээл); "Монголын эдийн засаг: шилжилтийн эдийн засгийн асуудал" УБ., 1999, "The Mongolian economy" 2000 зэрэг болно. Сүүлийн жилд 40 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл, 30 гаруй эрдэм шинжилгээний илтгэл хэвлүүлсэн.
9. **Л.Оюун.** МУИС-ийн ЭЗС-ийн Санхүүгийн тэнхмийн профессор багш, доктор Ph. Судалгааны үндсэн чиглэл: "Банкны үйлчилгээний үнэ бүрдүүлэлт". Сүүлийн 5 жилд "Банкны менежмент", "Төрийн мөнгөний бодлогоор" тус тус сурах бичиг хэвлүүлснээс гадна "Арилжааны банкны дампуурал", "Арилжааны банкны салбарын удирдлага", "Арилжааны банк ба үнэт цаас", "Олон улсын банкны тогтолцоо", "Банкны маркетинг" зэрэг монограф хэвлүүлж гадаад, дотоодын эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлж нийтлэл хэвлүүлсэн болно.
10. **С.Баатар.** МУИС-ийн ЭЗС-ийн Санхүүгийн тэнхмийн профессор багш, доктор Ph. "Эдийн засгийг татварын бодлогоор зохицуулах нь" сэдвээр Оросын эрдэмтэдтэй хамтран ажиллаж байгаа. 2000 онд "Хөрөнгө оруулалтын менежмент", 2002 онд "Төвлөрсөн төсвийн татварын орлогыг оновчтой болгох нь" зэрэг номуудыг бичиж, хэвлүүлсэн. "Микро түвшний санхүүгийн менежмент" чиглэлээр Японы эрдэмтэн Накамураатай хамтран ажиллаж байгаа.
11. **С.Анхбаяр.** Докторант. Эрхүүгийн Улсын Эдийн Засгийн Академийн аспирант. "Татвар, төсөв"-ийн чиглэлээр судалгаа хийдэг. "Санхүүгийн даяаршил" өгүүлэл 2002 онд "Үнэн" сонинд хэвлүүлсэн. Гол бүтээл нь: "Төсвийн онол, арга зүйн зарим асуудалд" ном. 2003 он. Эрхүү хот.
12. **Ч.Энхбаяр.** МУИС-ийн ЭЗС-ийн Санхүүгийн тэнхмийн багш, доктор Ph. "Татвар"-ын чиглэлээр судалгааны ажил хийдэг. Татварын сурах бичиг болон татварын байцаагчид зориулсан гарын авлага бичиж байгаа.
13. **Г.Бурмаа.** МУИС-ийн ЭЗС-ийн Санхүүгийн тэнхмийн ахлах багш, докторант. "Монгол улсын даатгалын тогтолцоог боловсронгуй болгох" сэдвээр судалгаа хийдэг. "Давхар даатгал, гэрээний хэлбэрүүд", "Зах зээлийн орнуудын даатгалын тогтолцоо" зэрэг гарын авлага бэлтгэж гаргасан. "Даатгалын үндэс" сурах бичиг бичиж байна.
14. **Ж.Уянга.** МУИС-ийн ЭЗС-ийн Санхүүгийн тэнхмийн багш, бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй. "Төвлөрлийг сааруулах асуудал ба орон нутгийн менежментийн асуудал" сэдэвт сургалтанд 2000 онд, "Төрийн санхүүгийн асуудал ба нийгмийн сонголт" сэдвээр 2001 онд тус тус сургалтанд хамрагдаж байсан. "Аж ахуйн нэгжийн төлөвлөлтийн асуудал"-аар судалгаа, шинжилгээний ажил хийдэг. "Аж ахуйн нэгжийн санхүү" сурах бичгийг орчуулж байгаа.
15. **Р.Гансүх.** МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, МУИС-ийн докторант. "Хөгжлийн эдийн засаг" чиглэлээр судалгааны ажил хийдэг. Сүүлийн үед хэвлэлд нийтлүүлсэн материал: "Гадаадын хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал", Санхүүгийн мэдээ сонин УБ., 2002 он, №12, 0.3х.х, "Үндэсний эдийн засгийн Монгол номлол" төслийн судалгааны тайлан IV бүлгийн 4.2, V бүлгийн 5.1, 2003.
16. **К.Аксолтан.** МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор /Ph/, дэд профессор. "Хөгжлийн эдийн засаг, өмч хувьчлал, нөөц хөгжил"-ийн асуудлаар судалгааны ажил хийдэг. Сүүлийн жилүүдэд хэвлүүлсэн бүтээлүүд: "Шилжилтийн үеийн хөдөөгийн асуудал" МУИС, ЭШ-ний бүтээл, УБ 1997, "Монгол улсын газрын өмчлөл" Өвөр Монголын зүүн хойд Ази судлалын институтын сэтгүүл, 1997 (хятад хэлээр), "Reform in industries and shareholding company" Problems of economic development (abstract from papers), 1996, УБ., "Капитал, капиталын хөдөлгөөн" ЭДИЙН ЗАСАГ: онол практик сэтгүүл, №2 2000, "Өмч хувьчлалын үр дүн, сургаж, дүгнэлт" ЭДИЙН ЗАСАГ: онол практик сэтгүүл №08 2003.
17. **П.Лувсандорж.** Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн гишүүн (академич), Эдийн засгийн ухааны доктор, профессор. Судалгааны чиглэл: "Хөгжлийн эдийн засаг". Сүүлийн үед хэвлэгдсэн бүтээлүүд: "Монголын эдийн засаг: шилжилтийн эдийн засгийн гарын авлага" Улаанбаатар-Манчестер. 1999; "Монгол улс: шилжилтийн эдийн засгийн стратеги" Edap joint policy studies4, KDI. 1998; "Шилжилтийн эдийн засаг: Монголын байдал ба туршлага" Northeast Asian Study Series 3. Tohoku University, 1999. THE MONGOLIAN ECONOMY: A Manual of Applied Economics for a Country in Transition. 2000 EE. Cheltenham, UK. Northampton, MA, USA. Шилжилтийн эдийн засгийн шинжлэх ухааны асуудлууд. "Үнэн" сонин. 2002.08.23, "Шилжилтийн эдийн засаг бол шинжлэх ухааны шинэ салбар мөн" ЭДИЙН ЗАСАГ: онол практик сэтгүүл №6 2002.